



Дорнод аймгийн Аудитын газар

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ
ҮАГ-НАГ-/2016/05-НА**



Сумд нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

**Чойбалсан хот
2016 он**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймгийн Аудитын
газрын Нийцлийн аудитын
баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул Утас: 70584203

Аудитын менежер
В.Цэнгэлмаа Утас: 70584207

Ахлах шинжээч:
Ж.Баяртуул Утас: 70584207

Шинжээч:
С.Энхбаатар
Утас: 70584207

2016 оны 9 дүгээр сар
Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70584207
дугаарын утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн
Сум, 7-р баг аймгийн ЗДТГ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Нэг: БОНХАЖЯ болон аймгийн ИТХ нь хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Хоёр: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Гурав: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БОХНС арга хэмжээнд хөрөнгө хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй, сумдад уг арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай огт төлөвлөөгүй байна.

Дөрөв: Мэргэжлийн байгууллагууд нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

АЛБАН ШААРДЛАГА

ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийг аудитын газар
НА	Нийцлийн аудит
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОНХАЖ	Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОХНС	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
МБОИЗ	Монголын байгаль орчны иргэдийн зөвлөл
	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон Дорнод аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго:

Байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн ИТХ, Засаг дарга байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх.
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, АЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материал, ажлын баримтад тулгуурлан гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн ИТХ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.2-д “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэж заасны дагуу 2014 онд аймгийн 2015 оны төсвийг батлахдаа байгалийн нөөцийн орлогыг 1'504.7 сая төгрөг, зарлагыг 697.5 сая төгрөгөөр баталж, 2015 онд тодотгол хийн орлогыг 500.0 сая төгрөгөөр өсгөн, зардлыг 304.3 сая төгрөгөөр бууруулсан байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС, Нийцлийн аудитын 4000-4200 дугаар стандарт, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, судалгаа авах, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийх, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Амьтны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймгийн Аудитын газрын нийцлийн аудитын багийн ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2015 оны 08 дугаар сарын 17-оос эхэлж, 9 дүгээр сарын 28-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторoor хянуулан баталгаажуулж, 2015 оны 10 дугаар сарын 03-ны өдөр ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, албан шаардлага болон тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 4 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуллаа.

I БҮЛЭГ: БОНХАЖЯ болон аймгийн ИТХ нь хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

1.1 БОНХАЖЯ нь байгаль орчныг нөхөн сэргээх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж төрийн захиргааны төв байгууллага болох БОНХАЖЯ-ны бүрэн эрхийг заажээ.

Тус яамны бүрэн эрхэд хамаарах асуудлаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу 2015 онд “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүнд”-д хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүдтэй холбоотой албан шаардлагыг хүргүүлсэн.

Албан шаардлагад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн баталгаа хөрөнгийн хэмжээнд хөнгөлөлт үзүүлэх тухай хуулийн шаардлагад нийцэхгүй гэрээг байгуулсан, мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хууль, журамд заасан хугацаанд баталдаггүй зэрэг зөрчлүүдийг арилгах тухай заасан.

Уг албан шаардлагын хариуг ирүүлээгүй бөгөөд мөн аймгийн Засаг даргаас Дашбалбар, Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрт “Шинь шинь” ХХК болон “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаанаас шалтгаалж байгаль орчинд үүссэн хохирлыг арилган, нөхөн сэргээлт хийлгэх талаар хамтран ажиллах тухай албан тоотыг хүргүүлэхэд тус нөхцөл байдлыг судалж буй тухай хариуг ирүүлсэн байна.

Дээрх асуудлууд үүсээд 2 жилийн хугацаа өнгөрч байхад байгаль орчны бохирдлыг арилгуулаагүй, нөхөн сэргээлтийг хийлгээгүй байгаа нь БОНХАЖЯ нь бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна.

1.2 Аймгийн ИТХ нь хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтын дагуу аймгийн 2015 оны төсвийг батлахдаа байгалийн нөөцийн орлогыг 1'504.7 сая төгрөг, зарлагыг 697.5 сая төгрөгөөр тогтоож, тодотголоор орлогыг 500.0 сая төгрөгөөр өсгөн, зардлыг 304.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төсвийг анх батлахдаа БОХНС сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 20 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 157,2 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь хуулийн шаардлагад нийцэхгүй байсан. Тодотголоор төсөл арга хэмжээний тоог 17 болгон өөрчлөн батлахдаа дээрх 2 арга хэмжээг хуулийн шаардлагад нийцэхгүй гэсэн үндэслэлээр бус төсөв хүндрэлтэй гэдэг шалтгаанаар хассан ч мөн уг сангаас санхүүжүүлэх шаардлагад нийцэхгүй БОАЖГ-ын түрээсийн төлбөрт олгох 5,0 сая төгрөгийн зардлыг нэмж оруулсан байна. Иймд аймгийн ИТХ-д төсөл, арга хэмжээний хуулийн шаардлагад нийцэх байдлыг харгалзан үзэж, батлах тухай албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын Байгаль орчин, газрын тос, уул уурхайн бодлогын хороо нь 2015 онд байгаль хамгаалах тухай үйл ажиллагаатай холбоотой сургалт зохион байгуулах, танилцах, хяналт тавих чиглэлээр нийт 19 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 25%-ийн биелэлттэй байна.

Үүнээс ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх сумдад зохион байгуулах, байгаль хамгаалах талаар иргэд, нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах, “Мэнэнгийн талын сав газрын захиргаа”-г аймагтаа шилжүүлэх, түгээмэл тархацтай ашигт малтмалыг зүй зохистой ашиглахад хяналт тавих, газрын тосны бүтээн

байгуулалтад Дорнод аймгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийг нэн тэргүүнд оролцуулах талаар анхаарч ажиллах, тэргүүлэгчдийн хурлаараа хэлэлцэх гэсэн 5 арга хэмжээг хэрэгжүүлж бусад 14 арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

1.3 Аймгийн Засаг дарга нь хуульд заасан эрхээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Төсвийн тухай хуульд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр нь аймгийн төсөвт орно гэж заасны дагуу аймгийн Засаг дарга нь 2015 онд 1,5 тэрбум төгрөгийн орлого олж, уг орлогын 46,3% болох 697,5 сая төгрөгийг нийт 20 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар батлуулсныг тодотголоор 2,0 тэрбумын орлого олж, 393,2 сая төгрөгийг нийт 17 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар өөрчлөн батлуулсан байна.

/Хүснэгт 1/

№	Төсөл арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	ИТХ-ын анхны тогтоолоор /сая/	ИТХ-ын тодотгол оор /сая/	Зөрүү /сая/
	Хуульд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээ			
1	Аймгийн хэмжээнд агаар, ус, хөрс, орчны бохирдлын судалгааг хийлгэж, хог хаягдлын тоо бүртгэл, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах	30.0	19.9	-10.1
2	Бохирдож доройтсон хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал /Хэрлэн сум/	80.0	0	-80.0
3	Эрээний нуруунд 210 га талбайг ойжуулах /Баян-Уул/	139.0	132.6	-6.4
4	Ойн хортон шавьж устгал, хортон шавьжийн голомтыг устгах	20.0	19.9	-0.1
5	Ойн түймрээс хамгаалах 30км халз зурвас байгуулах /Баян-Уул/	60.0	58.5	-1.5
6	2014 онд хийсэн ойн түймрийн зурвасын арчилгааны зардал /Баян-Уул/	15.0	10.0	-5.0
7	Мод үржүүлгийн газрын өргөтгөл /Баяндун/	8.0	7.5	-0.5
8	Булаг шандын эхийг хашиж хамгаалах, мод тарих	25.0	23.9	-1.1
9	Усны тоо бүртгэл явуулах	18.5	18.5	0
10	Чойбалсан хотын усан санг хамгаалах хашаа барих	2.4	2.4	0
11	Талбай хэмжих, газрын нөхөн сэргээлтийн зураглал хийх, тооцоолох, мэдээллийн сан үүсгэхэд ашиглах	12.5	12.5	0
12	Буйр нуурыг хамгаалах	20.0	19.7	-0.3
13	Хөв цөөрөм байгуулах /Баяндун/	0	45.0	45.0
14	БОХНС-гийн зардлаар санхүүжүүлж хэрэгжүүлсэн ажилд хяналт, шалгалт хийх	0	5.0	5.0
15	Уул уурхайн хайгуул ашиглалтын дараах БОМТ-ний биелэлтийн явцад хяналт тавих, хүлээн авах, үнэлэх дүгнэлт гаргах	5.0	5.0	0
16	Байгаль хамгаалах хавар намрын сурталчилгаа	10.0	0.4	-9.6
17	Байгаль хамгаалагчдын ажлын хэрэгцээний хувцас, унаа, тоног төхөөрөмж	15.0	0	-15.0
18	МБОИЗ болон нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	12.0	0	-12.0
19	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх сумдад зохион байгуулах	20.0	7.4	-12.6
20	МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар оршуулгын газрын өмнүүр 15 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах, хашаажуулах, худаг гаргах /Хэрлэн/	48.0	0	-48.0
	Дүн	535.3		-137.1
	Хуульд нийцээгүй хөтөлбөр, арга хэмжээ			
1	Аймгийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	115.0	0	-115.0
2	Монгол дайчдын хөшөөний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	42.2	0	-42.2
3	БОАЖГ-ын түрээс	0	5.0	5.0
	Дүн	162.2	5.0	-167.2
	Нийт дүн	697.5	393.2	-304.3

Эдгээр 17 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, биелэлтэд явцын хяналт тавих, хүлээн авах ажлыг зохион байгуулсан ч төсвийн байгууллагын урсгал зардал болох БОАЖГ-ын ажлын байрны түрээсийн 5,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн нь хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд БОХНС сангийн үйл ажиллагаанд хамаарахгүй арга хэмжээ юм.

БОНХАЖ-ын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 100% гэж дүгнэсэн байна.

II Бүлэг: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Байгалийн нөөц ашигласны тухай хуулийн зорилгыг “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгалийн нөөц ашигласны төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлэхэд оршино” гэж заажээ.

Аймаг, сумдын Засаг дарга нар нь Төсвийн тухай хуулийн 8.5.1¹, 8.5.3² дахь заалтуудын дагуу байгалийн нөөц ашигласны орлогыг дараах байдлаар төлөвлөн батлуулсан байна.

/хүснэгт 2/

№	Сумдын нэр	Байгалын нөөц ашигласны орлогын төрөл	Анхны тогтоол		Тодотгосон төсөв		Зөрүү
			Шийдвэрийн огноо, дугаар	Бат-н дүн /сая.төг/	Шийдвэрийн огноо, дугаар	Бат-н дүн /сая.төг/	
1	Дашбалбар	Ан агнуур		0		12.8	-12.8
2	Халхгол	Ан агнуур	2014.12.18 №	20.0	2015.12.18 №67	24.0	-4.0
3	Булган	Ан агнуур	2014.12.18 №	0	2015.12.01 №02	0.2	-0.2
	Дүн			20.0		37.0	-17.0
1	Баяндун	Ой мод		0	2015.11.11 №03	3.7	-3.7
2	Баян-Уул	Ой мод	2014.12.18 №16	63.0	2015.12.03 №04	46.5	16.5
	Дүн			63.0		50.2	12.8
1	Булган	Ургамал	2014.12.18 №	0	2015.12.01 №02	35.3	-35.3
2	Халхгол	Ургамал	2014.12.18 №	60.0	2015.12.18 №67	60.0	0
3	Цагаан-Овоо	Ургамал		0		15.0	-15.0
	Дүн			60.0		110.3	-50.3
1	Дашбалбар	Ус		3.0		0	3.0
2	Матад	Ус	2015.04.07 №04	32.0	2015.12.17 №4	12.0	20.0
3	Халхгол	Ус	2014.12.18 №	15.0	2015.12.18 №67	15.0	0
	Дүн			50.0		27.0	-31.5
1	Аймаг	Ус	2014.12.01 №07	1'504.7	2015.11.16 №06	2'004.7	-500.0
	Дүн			1'504.7		2'004.7	-500.0
	Нийт дүн			1'697.7		2'229.2	-531.5

Дээрх орлогыг төлөвлөхдөө тухайн онд ашиглах байгалийн нөөцийн судалгааг үндэслэн тогтоох шаардлагатай ч БОАЖГ нь нөөц ашиглах судалгааг 2015 оны төсвийг төлөвлөн батлахаас өмнө хийгээгүйгээс өмнөх жилийн дундаж хэмжээг баримтлан төлөвлөсөн байна. БОАЖГ 2015 онд ашиглах байгалийн нөөцийн хүсэлтийг 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр БОНХАЖЯ-нд хүргүүлсэн байна.

БОНХАЖ-ын сайдын тушаалаар Дорнод аймагт ашиглах нөөцийн хэмжээг дараах байдлаар тогтоосон байна.

/хүснэгт 3/

¹ аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

² сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

№	Тушаал гаргасан байгууллага	Шийдвэр гаргасан огноо	Зөвшөөрсөн газар	Төрөл зүйл	Зөвшөөрсөн тоо хэмжээ	Зориулалт
1	Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яам	2015.11.30 №А/402	Дорнод аймаг Халхгол сум Бүйр нуур	Загас	30.0 тн	Хэрэглээ
2	Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын яам	2014.10.31 №А/382	Дорнод аймаг	Ойн мод	2'044.0 м3	Хэрэглээ
3	БОНХАЖЯ-ны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар	2015.10.31 №05/6446	Дорнод аймаг	Идлэг шонхор	2 ширхэг	Соёл
4	БОНХАЖЯ-ны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар	2015.08.05 №05/4873 2015.08.07 №05/4941	Дорнод аймаг	Дэрэвгэр жирэвгэр	30.0 тн	Үйлдвэрлэл

Төсвийг тооцоо судалгаагүй баталснаас шалтгаалж байгалийн нөөцийн орлого төлөвлөсөн хэмжээнээс өөрчлөгдөх нөхцөл үүсэхэд аймаг болон сумд нь оны эцэст төсөвтөө тодотгол хийн төлөвлөгөөг гүйцэтгэлээр нь баталж байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2015 онд байгалийн нөөцийн орлогод 2,2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2,4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

/Хүснэгт 4/

№	Сумдын нэрс	Байгалийн нөөц ашигласны орлогын төрөл	ИТХ-ын тогтоол		Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
			Шийдвэрийн огноо, дугаар	Батлагдсан дүн /сая.төг/		
1	Дашбалбар	Ан агнуур		12.8	12.8	0
2	Халхгол	Ан агнуур	2015.12.18 №67	24.0	28.8	4.8
3	Булган	Ан агнуур	2015.12.01 №02	0.2	0.2	0
	Дүн			37.0	41.8	4.8
1	Баяндун	Ой ашиглалт	2015.11.11 №03	3.7	1.1	-2.6
2	Баян-Уул	Ой ашиглалт	2015.12.03 №04	46.5	48.0	-1.5
	Дүн			50.2	49.1	-4.1
1	Булган	Ургамал	2015.12.01 №02	35.3	35.3	0
2	Сэргэлэн	Ургамал		0	7.2	7.2
3	Халхгол	Ургамал	2015.12.18 №67	60.0	85.0	25.0
4	Цагаан-Овоо	Ургамал		15.0	15.8	0.8
	Дүн			110.3	143.3	33.0
1	Дашбалбар	Ус		0	0	0
2	Матад	Ус	2015.12.17 №14	12.0	14.8	2.8
3	Халхгол	Ус	2015.12.18 №67	15.0	0	-15.0
	Дүн			27.0	14.8	-12.2
1	Аймаг	Ус	2015.11.16 №06	2'004.7	2'255.2	152.8
	Дүн			2'004.7	2'255.2	152.8
	Нийт дүн			2'229.2	2'270.0	177.3

Байгалийн ургамлын нөөцийн орлого 18,5%, агнуурын нөөцийн орлого 3,5%, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны орлого 1,1%-иар тус тус давж биелсэн байна.

Энэ нь Буйр нуураас ахуйн зориулалтаар барих загас төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдсэн, Халхгол суманд 2 аж ахуйн нэгж 20,0 тн дэрвэгэр жирвэгэрийг зөвшөөрөлгүй түүж, төлбөрийг сумын төсөвт төвлөрүүлсэн, “Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ний усны хэрэглээ өссөн зэрэг шалтгаануудтай холбоотой байна.

Мөн аймгийн төсөвт 2015 онд байгалийн нөөцийг хууль бусаар ашигласны торгуулийн 46.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

III Бүлэг: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БОХНС арга хэмжээнд хөрөнгө хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй, сумдад уг арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай огт төлөвлөөгүй байна.

3.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БОХНС арга хэмжээний зардалд хөрөнгө хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.

Тухайн төсвийн жилд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д дараах байдлаар заажээ.

/Хүснэгт 5/

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Зарцуулах хувь, хэмжээний доод хязгаар		Зарцуулах хувь, хэмжээг тогтоосон хуулийн үндэслэл
	2014 он	2015 он	
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	30 хувь	15 хувь	2015 оны 1 сард батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн өөрчлөлт”
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	55 хувь	35 хувь	
Газрын нөөцийн төлбөрийн орлого	30 хувь	15 хувь	
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь	50 хувь	2012 оны 5 сард батлагдсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”
Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь	50 хувь	

Төсвийн тухай хууль болон Татварын ерөнхий хуульд эдгээр орлогоос ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрэлдэхүүн болох үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогоос бусад орлогыг сумын төсөвт төвлөрүүлэхээр заасан байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн хувь хэмжээ нь хуульд зааснаас бага байна.

/сая төгрөгөөр/

он	Төлөвлөгөө			Зөрүү
	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны	Зарцуулахаар төлөвлөх хэмжээ	Зарцуулахаар төлөвлөсөн хэмжээ	

	төлбөрийн орлого			
2014.12.01	1504.7	827.6	697.5	130.1
2015.11.16	2004.7	701.6	393.2	308.4

Аймгийн ИТХ-аас уг зардлыг анх батлахдаа хуульд заасан хэмжээнээс 130,1 сая төгрөгөөр, тодотгол хийхдээ 308.4 сая төгрөгөөр тус тус дутуу баталсан байна.

Энэ нь Засаг дарга болон түүний дэргэдэх агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь төсвийн төсөлд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг хуульд заасны дагуу тооцон оруулаагүйтэй холбоотой байна.

Иймд аймгийн төсвийн төслийг боловсруулахдаа дээрх зардалд хуваарилах хөрөнгийг хуульд заасан хувь хэмжээний дагуу тооцож байх шаардлагатай байна.

3.2-3.4 Сумд нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хөрөнгө огт хуваарилаагүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэхийг үзэхэд Баяндун, Баян-Уул, Булган, Дашбалбар, Матад, Халхгол, Цагаан-Овоо сумд нь 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогод нийт 193.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах талаар огт төлөвлөөгүй байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-т уг орлогын хэсгийг дараах байдлаар зарцуулахаар заажээ. Үүнд:

- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг нэн ховор, ховор ургамлын нөөцийг тарималжуулах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээ хийх, бэлчээрийн менежментийг сайжруулах, ашиглалтад хяналт тавихад,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг хайгуул, судалгаа хийх, усан хангамжийг сайжруулах, усны тухай хууль тогтоомжийг мөрдүүлэх, хамгаалалтын бүс байгуулах, тохижуулах, усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, ойн мэргэжлийн байгууллагыг дэмжих, түймрээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах, хяналт шалгалт хийхэд,
- Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, амьдрах орчинг нөхөн сэргээх, судалгаа, мониторинг хийх, хууль хэрэгжүүлэх нөхцлийг хангах, сургалт сурталчилгаа, хяналт шалгалт хийхэд тус тус зарцуулах.

Аймгийн хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн орлогын хэсгийг хууль, тогтоомжийн дагуу зарцуулсан эсэхийг үзэхэд 2015 онд нийт 17 хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 393.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах арга хэмжээнд – 24.9 сая төгрөг
- Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд – 235.9 сая төгрөг
- Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээнд – 89.8 сая төгрөг
- Байгаль орчны чиглэлийн сургалт, сурталчилгааны ажилд – 37.6 сая төгрөг

➤ Зориулалт бусаар /ажлын байрны түрээс/ - 5,0 сая төгрөг

Сумдын хувьд БОХНС арга хэмжээнд хөрөнгө хуваарилаагүй шалтгаан нь, сумдын Засаг дарга нар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж, төвлөрүүлсэн сумд нь уг орлогын хэсгийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсаар байна.

Иймд сумдын Засаг дарга нарт холбогдох хууль, тогтоомжийг биелүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага өглөө.

3.5. Байгалийн нөөц ашигласан төлбөр төлөгчид хуульд заасны дагуу хөнгөлөлт үзүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх харилцаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулагдаж байна.

Байгалийн ургамал ашигласны төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол хувь хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн ИТХ тогтооно гэж хуульд заажээ. Аймгийн ИТХ-ын зүгээс байгалийн ургамал ашигласны төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол хувь хэмжээг тогтоосон тогтоол байхгүй байна. БОНХАЖЯ-аас 2015 онд Дорнод аймагт 30 тонн дэрэвгэр жирэвгэр түүх зөвшөөрлийг л аж ахуйн нэгжүүдэд өгсөн байна. Дэрэвгэр жирэвгэр нь БОНХАЖ-ын Сайдын 2015 оны “Байгалийн ургамлын ангилал тогтоох тухай” А/268 дугаар тушаал зааснаар хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх элбэг ургамлын нөөцөд хамаардаггүй байна.

Орон нутагт ус ашиглуулах дүгнэлтийг усны сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчны алба, сумын Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтан гаргаж байгаа бөгөөд уг дүгнэлтээр усны нөөцийн төлбөрийн хэмжээг хууль тогтоомжийн дагуу ногдуулан тооцож байна. Ус ашигласан төлбөр төлөгчид ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолоор батлагдсан “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай журам” –ын дагуу хөнгөлөлт үзүүлэх тохиолдол гараагүй байна.

Аймгийн ИТХ нь тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг Ойн тухай хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум бүрээр тогтоож, сумын ИТХ нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн мэргэжлийн байгууллагын менежментийн төлөвлөгөө болон иргэдийн хэрэгцээг үндэслэн ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг тогтоодог байна. Ойн нөөц ашигласны төлбөрийн хувьд хилийн бүсийн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч өөрийн ажлын байрны хэрэгцээнд мод бэлтгэсэн тохиолдолд чөлөөлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашиглавал төлбөрийг хөнгөлж болох бөгөөд хөнгөлөлтийн хувь, хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж заасан байна.

Дорнод аймагт Бавжбарс ХХК, Өвөр эрээн ХХК, Нарс мод ХХК-иуд нь ойн санг гэрээгээр эзэмших эрх авч гэрээ байгуулсан байна. Ойн нөөц ашигласны төлбөрийг хуульд заасны дагуу хөнгөлөх нөхцөл гараагүй байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувьд Дорнод аймгийн хэмжээнд 2015 онд Халхгол, Дашбалбар сумдад ан амьтан барих зөвшөөрлийг олгосон бөгөөд соёлын зориулалтаар барьсан 2 идлэг шонхорын төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22.2-т заасан хязгаарт багтаан 60% хөнгөлсөн байна.

IV Бүлэг: Мэргэжлийн байгууллагууд нь Байгаль орчныг хамгаалах тухай

хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

4.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Амьтны тухай хууль, Ойн тухай хууль болон бусад холбогдох заавар журмаар зохицуулагддаг байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, ИТХ, мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн захиргааны бусад төв байгууллагын байгаль орчныг хамгаалах талаарх бүрэн эрхийг заасан байна.

4.2. Мэргэжлийн байгууллагууд нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заажээ.

Аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 2015 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хууль тогтоомжийн дагуу 10 удаа хийж хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна. Хяналт шалгалтаар 2015 онд хууль бусаар түүж бэлтгэсэн ургамлын үндсийг хураах 3 акт, ургамлын санд учруулсан шууд хохирлыг тогтоосон 4 дүгнэлт гаргаж, 2 аж ахуйн нэгж, 1 иргэний зөрчлийг Цагдаагийн газарт шалгуулахаар шилжүүлж, 4338 кг ургамлын үндсийг улсын орлого болгох арга хэмжээ авсан байна.

Аймгийн БОАЖГ нь 2015 онд байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу хяналт тавьж ажилласан байна. Үүнд:

- БОНХАЖЯ-аас Дорнод аймагт байгалийн ургамал түүх зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжүүдэд түүх газрыг зааж өгч, газар дээр нь 2 удаа хяналт шалгалт хийж ажилласан байна. Хяналт шалгалтыг 3 үе шаттай явуулж, 27 зөрчил илрүүлж, хууль бусаар түүхийг завдсан 22 иргэн, бэлтгэсэн 508.5 кг дэрэвгэр жирэвгэр ургамал, 32 ширхэг багаж хурааж улсын орлого болгосон байна.
- Аймгийн нутагт газрын тос, ашигт малтмалын чиглэлээр ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд 06, 07, 10 сард зөвлөн туслах, хяналт мониторинг, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, нийт 18 ААН-ийг хамруулсан байна. Үүнд: байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд дүгнэлт гаргаж ажилласан байна.

Тосон хулстайн байгалийн нөөц газарт хамрагдах 5 сумдын нутаг болон орчны бүсэд аймгийн БОАЖГ, мэргэжлийн хяналтын байгууллага, сумын байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг гүйцэтгэсэн боловч зөрчил илрээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. БОНХАЖЯ нь байгаль орчныг нөхөн сэргээх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

2. Аймгийн ИТХ нь хяналт тавих эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. Аймгийн Засаг дарга нь хуульд заасан эрхээ хэрэгжүүлэн ажилласан байна.
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.
5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.
6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БОХНС арга хэмжээний зардалд хөрөнгө хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.
7. Сумд нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хөрөнгө огт хуваарилаагүй байна.
8. Сумд нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.
9. Байгалийн нөөц ашигласан төлбөр төлөгчид хуульд заасны дагуу хөнгөлөлт үзүүлсэн байна.
10. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.
11. Мэргэжлийн байгууллагууд нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

21000, Чойрболсал, Дорнод аймаг,
Утас: 7058-3040, факс: 7058-4681

2016-10-06 № 2/16020

танай -ны № -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ
ТАНАА

Г Байгаль хамгаалах сангийн тухай

Орон нутгийн 2015 оны төсвийн төсөлд байгалийн нөөц ашигласны төлбөрүүдийн холбогдох орлогын дүнд үндэслэн 697,5 сая төгрөгөөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг Сангийн яаманд хүргүүлсэн.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас төсвийн орлогын төлөвлөгөөг нэмж хянасан бөгөөд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 739,8 сая төгрөгөөр хянаж өгөх байсан боловч оны эхэнд 697,5 сая төгрөгөөр, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой 478,9 сая төгрөгөөр тус тус хянасан.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 2015 онд 75,9 сая төгрөгөөр дутуу хянаж баталсан болно.

Мөн 2016 оны төсөвт, 2017 оны төсвийн төслөөр байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг дутуу хянаж байгаа болно.

ДАРГА



П.БАТ-ӨЛЗИЙ

01 553

Дорнод аймгийн Аудитын газрын тайлбар:

Аймгийн ЗДТГ-аас байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг журмын дагуу төлөвлөн Сангийн яаманд хүргүүлэн хянуулахад, Сангийн яам байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн зардлыг бууруулсан тухай тайлбар ирүүлсэн.

Уг тайлбарыг үндэслэлтэй эсэхийг судлан үзэхэд 2014 онд Сангийн яаманд хянуулахаар хүргүүлсэн 2015 оны төсвийн төсөлд зарлагыг хууль, журамд заасны дагуу төлөвлөн хүргүүлэхэд Сангийн яам орлогыг нэмж, зарлагыг хэвээр ирүүлсэн нь нотлогдож байна. Гэвч Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь төсвийн төслийг ИТХ-д өргөн мэдүүлэхдээ Сангийн яамнаас ирүүлсэн хязгаарыг баримтлаагүй байгаа бөгөөд мөн л орлогыг хянасан хэмжээнээс 400,0 сая төгрөгөөр өсгөсөн ч зардлыг хэвээр оруулсан байна. Энэ нь Санхүү, Төрийн сангийн хэлтэс төсвийг боловсруулахдаа яамны хянасан хэмжээг мөрдсөн гэснийг нотлохгүй байна.

Төсөвт 2015 онд тодотгол хийхдээ орлогоо 500,0 сая төгрөгөөр өсгөн, зардлаа Сангийн яамнаас ирүүлсэн дүнгээс 106,2 сая төгрөгөөр бууруулсан байна.

Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос зарцуулах зардлыг бодитой төлөвлөөгүй гэсэн дүгнэлтийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000. Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2016.10.06 № 1/1621

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны
үр дүн болон байгаль орчны хуулийн хэрэгжилтэд
хийсэн нийцлийн аудитын гаргасан дүгнэлт,
зөвлөмжийг хүлээн авч танилцлаа.

Танай ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу үе
шаттай ажил зохион байгуулж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН



01 519



ДОРНОД АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

21075, Чойбалсан, Дорнод аймаг
Утас/Факс: 7058-3529

2016.09.27 № 190

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сан болон байгаль орчны багц хуулийн хэрэгжилт сэдвээр хийсэн нийцлийн аудитаар өгсөн дүгнэлт зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* С.МӨНХСАЙХАН



23 223

ЗӨВЛӨМЖ

БОНХАЖЯ-нд байгаль орчныг нөхөн сэргээх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмж хүргүүлэх саналыг УАГ-ын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Алтанзулд уламжилж байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох-д:

1. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд тавих ИТХ-ын хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн-д:

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж байх.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс БОХНС арга хэмжээний зардалд хөрөнгө хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлан ажиллах.

Сумдын Засаг дарга нарт:

4. Сумд нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хөрөнгө хуваарилж ажиллах.
5. Сумд нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгөөр төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах 5 зөвлөмж, 2 албан шаардлага өгч ажиллалаа.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 22

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаал, 2003 оны 53 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах тухай журам"-ын 4.2 дахь заалт, аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн /"Байгаль хамгаалах сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан"/, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангуудыг баталсугай.

2. Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Алтанзул, аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мөнхсайхан, Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, МСҮТ-ийн захирал Т.Гантулга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер В.Цэнгэлмаад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



11 166

2016.10.07

Аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 оны 10 дугаар
сарын 07 өдрийн 22 тоот тушаалын хавсралт



Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Төлбөрийн актын утга	Мөнгөн дүн
1	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Насны хязгаар давсан суралцагчдад тэтгэлэг олгосон	1,686,210
2	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Хичээлдээ суугаагүй суралцагчдад тэтгэлэг олгосон	439,444
3	МСҮТ	ҮАГ-НАГ/2016/03-НА	Хичээлдээ суугаагүй суралцагчдад тэтгэлэг олгосон	323,273
Дүн				2,448,927

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	Политехник коллеж	ҮАГ-НАГ/2016/03-НА	Журам мөрдөж ажиллах	10,501,967
2	Аймгийн ИТХ	ҮАГ-НАГ/2016/05-НА	Хууль, журам мөрдүүлэх тухай	-
3	Баян-Уул сумын Засаг дарга	ҮАГ-НАГ/2016/05-НА	Журам мөрдүүлэх тухай	-
Дүн				10,501,967



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7 дугаар баг
З/ДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.09.30 № 02/НАГ/НАГ/2016/05-НА
танай _____-ны № _____-т

Г Хууль мөрдүүлэх тухай Г

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Л.ХИШИГТОГТОХ ТАНАА


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ИТХ нь аймгийн 2015 оны төсвийг батлахдаа аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх сангийн 162,2 сая төгрөгийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд хамаарахгүй төсөл арга хэмжээ болон урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

ИТХ нь 2015 онд төсвийг батлахдаа зардлыг зориулалтын дагуу зарцуулах эсэхэд хяналт тавьхгүй байгаа нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22.1.9 “Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих”, Засгийн газрын 2014 оны 43 тоот “Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дахь төлбөрийн орлогын зарцуулах тухай заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”, 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай”, 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг батлахдаа дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтоход даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ**ЗӨВШӨӨРСӨН:**

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." Гэжзаасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7 дугаар баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2016.09.30 №01/НС-НАГ-НАГ/2016/05-НА

танай _____ -ны № _____ -т

Журам мөрдүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Уул сум нь 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах талаар огт төлөвлөөгүй байна.

Тус сумын Засаг дарга нь 2015 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулаагүй нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”, 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторуудад зөвшөөрөх бүрэн эрхийн тухай”, 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д “... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг төлөвлөж байх,

дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Баян-Уул сумын Засаг дарга Ж.Доржид даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:
АХЛАХ ШИНЖЭЭЧ Ж.БАЯРТУУЛ
ШИНЖЭЭЧ С.ЭНХБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:
ЗАСАГ ДАРГА Ж.ДОРЖ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." Гэжээсны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.